



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 1164

Шивээговь сум

Сумын Засаг даргын “Жуух бичиг”-ээр
шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5, сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/15 дугаар захирамжаар батлагдсан “Сумын Засаг даргаас олгох шагналын журам”-ын 2.1.3, 5:6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. XVII жарны Үзэсгэлэн болгогч хэмээх Усан туулай жилийн Сар шинийн баярыг тохиолдуулан сум, орон нутагтаа идэвх санаачлагатай ажилласан хувиараа хөдөлмөр эрхлэгч Базарын Мягмаржав, Цогтбаярын Алтаннавч, Батаагийн Бадамдовжид, 2-р багийн малчин Бүрэнцэцэгийн Оюунтуул нарыг Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнасугай.

2. Шагналд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 120,000 (нэг зуун хорин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

4. Холбогдох ажлыг зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ), нярав (Б.Энхцэцэг) нарт, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

72
Сумын Засаг даргын 2023 оны 02-р сарын 17-ны өдрийн 164 дугаар захирамжийн хавсралт



“ЖУУХ БИЧИГ” ШАГНАЛД ЗАРЦУУЛАГДАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

2023.02.16

№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Засаг даргын “Жуух бичиг”				
1	Мөнгөн шагнал	4	30,000	120,000
Нийт				120,000